



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 07 сарын 23-ны  
өдрийн 396.8 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.4, Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Авто замын тухай" хууль батлагдсантай холбогдуулан "Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

3. Тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтыг дэлгэрэнгүй хөтөлж, тусгай мэдээллийн сан бүрдүүлэн ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 47 дугаар тушаал, Зам, тээврийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 152 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

САЙД  Ж.БАТ-ЭРДЭНЭ

Бүртгэлийн дугаар 260  
080314  
МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАГ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг  
2018 оны 07 сарын 20-ний өдөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2018 оны Дугаар сарын 18 ны өдрийн  
131 тоот тушаалын хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ  
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИХ, АРЧЛАХ, ЗАСВАРЛАХ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН  
ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргасан, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн хэлбэрийг үл харгалзан тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын хавсралтад заасан суурь нөхцөл шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагад 2.8-д заасан үйл ажиллагааны төрлөөр тусгай зөвшөөрөл олгоно.

1.3. “Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл-ийг /цаашид тусгай зөвшөөрөл гэх/ ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг үндэслэн авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.


**Хоёр. Тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах баримт бичгийг**

**бүрдүүлэх, эрх олгох нөхцөл**

2.1. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахыг хүссэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бааз, техникийн хангамж, инженер техникийн мэргэжлийн ажилчид болон бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гаргах ажлын хэсгийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулна.

2.2. Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон мэдээллийн сан бүрдүүлэх, баяжилт хийх, цахим хэлбэрт шилжүүлэх, тайлан мэдээг авч дүн шинжилгээ хийх, дүнг тайлагнах ажлыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн бус байгууллага хариуцна.

2.3. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасан бичиг баримтыг бүрдүүлнэ.





2.4. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Үүнд:

2.4.1. Хүсэлт гаргагчийн мэдээлэл

2.4.2. Холбогдох ажлын үйл ажиллагааны төрлийг хүссэн өргөдөл

2.4.3. Удирдах ажилтнуудын мэдээлэл

2.4.4. Инженер техникийн ажилтны мэдээлэл

2.4.5. Машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтын мэдээлэл

2.4.6. Үйлдвэрлэлийн баазын мэдээлэл

Ажлын хэсэг өргөдлийг хүлээж авснаас хойш дүгнэлт гаргах явцад шаардлагатай бусад баримт бичгийг шаардаж болно.

2.5. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахыг хүсэгч аж ахуйн нэгж нь энэ журмын хавсралтад заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллагаас энэ журмын 2.3, 2.4, 2.5-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу ажлын 21 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

2.7. Ажлын хэсэг зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллагын инженер-техникийн ажилтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник хангамжтай шаардлагатай тохиолдолд газар дээр нь танилцаж, ирүүлсэн материалыг хянан үзэж тусгай зөвшөөрлийг олгох дүгнэлт гаргана.

2.8. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл

**2.8.1 Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:**

2.8.1.1 Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах

2.8.1.2 Төв замын зураг төсөл боловсруулах

2.8.1.3 Хуримтлуулагч замын зураг төсөл боловсруулах

2.8.1.4 Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах

2.8.1.5 Хөдөө орон нутгийн замын зураг төсөл боловсруулах

2.8.1.6 Нисэх буудлын хөөрч буух зурвасын зураг төсөл боловсруулах


2.8.1.7 Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах

**2.8.2 Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд:**

2.8.2.1 Хатуу хучилттай зам барих

2.8.2.2 Хайрган хучилттай зам барих

2.8.2.3 Бүх төрлийн гүүр, тунель, үерийн хамгаалалтын далан барих



2.8.2.4 Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл

2.8.2.5 Бүх төрлийн зам, гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил

2.8.2.6 Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах

2.8.2.7 Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил

**2.8.3 Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:**

2.8.3.1 Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх

2.9. Тусгай зөвшөөрлийг энэхүү журмын 2.3, 2.4, 2.5, болон хавсралтад заасан нөхцөл, шаардлагыг хангасан Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн инженер техникийн ажилчдын 70-аас доошгүй хувь нь дотоодын инженер техникийн ажиллагсад байх шаардлагыг хангасан байгууллагуудад 2.8-д заасан үйл ажиллагааны төрлөөр 3 жилийн хугацаатай олгоно.

**Гурав. Тусгай зөвшөөрөл авах аж ахуйн нэгжид тавигдах ерөнхий шаардлага**

3.1. Тусгай зөвшөөрөл авах аж ахуйн нэгж нь эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамаарч журмын хавсралтад заасан инженер техникийн ажилтан болон холбогдох мэргэжилтэй, үндсэн ажиллагсадтай байна.

3.2. Инженер-техникийн ажилтнуудын мэргэжлийн дипломын хуулбарыг хавсаргана. Шаардлагатай тохиолдолд эх хувийг шалгана.


3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь чадавхын мэдээлэл, инженер техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг тухай бүрд нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.4. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь тухайн ажлыг гүйцэтгэхэд технологийн бүрдэл, тоо хэмжээ, ашиглалтын шаардлага хангасан байхын зэрэгцээ нийт машин механизм, тоног төхөөрөмжийн 60-аас доошгүй хувь нь тусгай зөвшөөрөл хүсэж байгаа аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй өөрийн өмчлөлийн машин механизм, тоног төхөөрөмжтэй байна.

3.5. Зарим машин механизм, тоног төхөөрөмжийг түрээсээр ажиллуулж болох ба энэ тохиолдолд түрээслүүлэгч байгууллагатай түрээсийн гэрээ байгуулсан байна. Тоног төхөөрөмжийн техник ашиглалтын байдлыг харуулсан техникийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулан түрээсийн гэрээнд хавсаргана.

3.6. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь авто замын салбарт үйл ажиллагаа явуулахад мөрдөх Үндэсний стандарт, норм норматив болон бусад техникийн баримт бичгийн бүрдэлтэй байх ба баримт бичиг худалдан авсан баримтыг хавсаргана.

3.7. Тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийн үнэн зөв болохыг баталгаажуулан аж ахуйн нэгж, байгууллагын захирал /дарга/ гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.





***Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сунгах***

4.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн зөрчил дутагдлыг арилгуулна.

4.2. Дээр дурдсан нөхцөл байдал үүссэнийг нотолсон эрх бүхий байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг ажлын хэсэг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д заасны дагуу харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

4.4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл, байдал арилсан тухай гомдол гаргасан захиалагч болон мэргэжлийн хяналтын байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээж болно.

4.5. Тусгай зөвшөөрлийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг үндэслэн хүчингүй болгоно.

4.6. Тусгай зөвшөөрөл олгох дүгнэлт гарснаас хойш 3 сарын дотор тэмдэгтийн хураамжийг төлөх бөгөөд хугацаандаа төлөөгүй тохиолдолд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасныг үндэслэн хүчингүй болгоно.

4.7. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон мөн тусгай зөвшөөрлөө гээгдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага шаардлага хангасан нөхцөлд зөвшөөрөл авах хүсэлтээ дахин гаргаж болно. Тусгай зөвшөөрлийг үрэгдүүлсэн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгохыг хүссэн өргөдөл, тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үндэслэн гэрчилгээг нөхөж олгоно.

4.8. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 30 хоногийн өмнө тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь уг зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ Ажлын хэсэгт хүргүүлнэ.

4.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх талаар энэхүү журмын 2.1-т заасан ажлын хэсэг дүгнэлт гаргана.

4.10. Ажлын хэсэг тусгай зөвшөөрлийг сунгах эсэх тухай гаргасан дүгнэлтээ Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэрлүүлнэ. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгах ба голлох бичиг баримтыг дахин бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:


4.10.1. Хүсэлт гаргагчийн мэдээлэл

4.10.2. Холбогдох ажлын төрлийг хүссэн өргөдөл

4.10.3. Инженер техникийн ажилтны мэдээлэл

4.10.4. Урьд жилүүдэд хийж гүйцэтгэсэн ажлууд /Хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, ажил хүлээлцсэн болон ашиглалтад оруулсан акт зэргийг хавсаргах /

4.10.5. Механизм тоног төхөөрөмжийн мэдээлэл




4.10.6. Санхүүгийн мэдээлэл

**Тав. Зөвшөөрөл олгоход авах хураамж**


5.1. Тусгай зөвшөөрөл олгоход Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг баримтлан тэмдэгтийн хураамж авч, улсын төсөвт шилжүүлнэ.

5.2. Тусгай зөвшөөрөл олгох шаардлага хангасан аж ахуйн нэгж нь тэмдэгтийн хураамжийг төлнө.

5.3. Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг Монгол Улсын холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.




Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн  
13.1 тоот тушаалын хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

УЛААНБААТАР ХОТ  
2018






НЭГ. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:


Нийтлэг нөхцөл шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
2.8.1.1. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах	Авто замын инженер-2	Аль нэг авто замын инженер нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай. /3-с дээшгүй аж ахуйн нэгжид гэрээт байж болно/
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багажнуудыг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Инженер-эдийн засагч-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно/
2.8.1.2. Төв замын зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 30 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай	Авто замын инженер-3	Аль нэг авто замын инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх. /Гэрээт байж болно/
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./






авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна/	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.
2.8.1.3. Хуримтлуулагч замын зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 6 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, хиймэл байгууламж авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна/	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
2.8.1.4. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 30 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.




газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна./	Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 3-аас багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх./Гэрээт байж болно./
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд Мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх.
	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
2.8.1.5. Хөдөө орон нутгийн замын зураг төсөл боловсруулах	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 1	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх.
	Аэродромын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх.
2.8.1.6. Нисэх буудлын хөөрч буух зурвасын зураг төсөл боловсруулах	Авто замын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн мэргэшсэн инженер байх.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх.






	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 2	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.
2.8.1.7 Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах /30 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна./	Гүүрийн инженер-2	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, аль нэг инженер нь Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх.
	Авто замын инженер - 1	Тухайн мэргэжлээрээ 6-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын зураг төслийн ажилд ажилласан байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох програм хангамжтай байх.




ХОЁР.Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд  
Нийтлэг нөхцөл шаардлага:Ажлын туршлагатай байх /хүснэгтэнд зааснаар/  
Ерөнхий нөхцөл шаардлага:

Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		Хатуу хучилттай	Хайрган хучилттай	Бүх төрлийн гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам барих
<b>А. Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>				
1	Эксковатор /0.65м³/	2	Түрээс байж болно.	1
2	Бульдозер /130м.х/	1	1	1
3	Автогрейдер /250м.х/	2	1	Түрээс байж болно.
4	Ачигч /1.0м³/	3	1	2
5	Доргиурт индүү /10 тн-оос дээш/	2	1	1
6	Хийн дугуйт индүү /20 тн/	1		
7	Асфальтны индүү	1		
8	Автогудронатор /3.5 м/	1		1
9	Өөрөө буулгагч	10	3 нь түрээс байж болно.	3
10	Усны машин /5 тн-оос дээш/	2	1	1
11	Асфальт дэвсэгч /7.0м-ээс багагүй/	Түрээс байж болно.		
12	Авто Кран /25 тн-оос дээш/	1		2
13	Шигшүүртэй чулуу бутлуур /60 тн/цаг/	Түрээс байж болно.		
14	Асфальтобетон завод /80 тн/цаг/	Түрээс байж болно.		
15	Лаборатор/иж бүрэн/	Түрээс байж болно.		
16	Геодезийн иж бүрдэл	Түрээс байж болно.		
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
18	Ерөнхий инженер	1	1	1
19	Авто замын инженер	2	1	1
20	Гүүр, хиймэл байгууламжийн инженер	1		2
21	Геодезийн инженер	1	1	1
22	Материалын инженер	2	1	1
<b>Б. Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>				
1.	Нэмэлт тайлбар:	Ерөнхий инженер нь 8 жилийн ажлын туршлагатай зөвлөх буюу мэргэшсэн зэрэгтэй байх, Гүүр, хиймэл байгууламж, авто замын инженерүүд 5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн зэрэгтэй байх,Бусад заасан инженерүүд 3-5 жилийн ажлын туршлагатай аль нэг инженер нь мэргэшсэн байх.	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай,мэргэшсэн инженер байх, Бусад заасан инженерүүд 1-3 жилийн ажлын туршлагатай байх.	Ерөнхий инженер нь ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх, Гүүрийн инженерийн нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх,





Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл			
		Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл	Бүх төрлийн зам, гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил	Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах	Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил
<b>А. Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм хамгийн бага тоогоор</b>					
1	Эксковатор /0.65м³/		1	Түрээсээр байж болно.	
2	Бульдозер /130м.х/				
3	Автогрейдер /250м.х/		2/1 нь түрээс байж болно/.	Түрээсээр байж болно.	
4	Ачигч /1.0м³/	1	1	Түрээсээр байж болно.	
5	Доргиурт индүү /10 тн-оос дээш/			Түрээсээр байж болно.	
6	Хийн дугуйт индүү /20 тн/				
7	Асфальтны индүү				
8	Автогудронатор /3.5 м/				
9	Өөрөө буулгагч	1			
10	Усны машин /5 тн-оос дээш/				
11	Автосамосвал		3		
12	Авто Кран /25 тн-оос дээш/		2 /1 түрээсээр байж болно/		
13	Шигшүүртэй чулуу бутлуур /60 тн/цаг/	Түрээс байж болно.			
14	Асфальтобетон завод /80 тн/цаг/	1			
15	Лаборатор/иж бүрэн/				
16	Геодезийн иж бүрдэл				
17	Бетон узель	2	1		
18	Замын тэмдэг үйлдвэрлэх тоног төхөөрөмж, тэмдэглэгээний машин				1
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>					
18	Ерөнхий инженер		1		
19	Авто замын инженер	1	1	1	1
20	Гүүр, хиймэл байгууламжийн инженер				
21	Геодезийн инженер		1		
22	Материалын инженер	2	1	1	
<b>Б. Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>					
1.	Нэмэлт тайлбар:	Материалын инженерийн нэг 3-5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх	Ерөнхий инженер нь мэргэшсэн зэрэгтэй, ажлын 5 жилийн туршлагатай байх	Ажлын туршлагатай байх	Ажлын туршлагатай байх



ГУРАВ. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:

2.8.3. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх	/Ерөнхий инженер/	Зам барилгын ажилд 10 жил,үүнээс 8-аас доошгүй жил зураг төслийн болон хяналтаар ажилласан, тэргүүн зэрэгтэй,зөвлөх болон мэргэшсэн инженер байх /Гэрээгээр байж болно/.
	Замын инженер-2	Зам барилгын 10 жил, чиглэлээр 5 жил 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, замын инженерийн мэргэжилтэй байх. Аль нэг инженер нь мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Зам барилгын чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Материалын инженер-2	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер мэргэшсэн, ахлах инженер байх.
	Тоо хэмжээний инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн төсөвчин,инженер байх.
	Хэмжилтийн инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженер, мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл геодезийн инженер мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох програм хангамжтай байх.

- ИТА-ын нийгмийн даатгалын дэвтрийг хуулбарлаж, нотариатаар баталгаажуулан өргөдөлд хавсаргах.
- Баталгаажсан нийгмийн даатгалын тайланг НД-7, НД-8 маягтын дагуу ирүүлэх.
- Диплом болон техникийн гэрчилгээ, жолооны үнэмлэх болон бусад нотлох баримтын хувийг нотариатаар баталгаажуулан хавсаргах.

---oOo---

Бүртгэлийн албаар *Л.О*  
 МОНГОЛ УРСАМ  
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨЛӨВЧИЙН АЖЛЫН  
 ХУУЛБАР ҮНЭН  
 хуулбар олгосон гэрчилгээний гарын үсэг  
*all*  
 2015 оны 07 сарын 20 ний өдөр